



2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ПРОТОКОЛ

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК -ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18-р хороо Эл Эс плаза, 2 давхар 203 тоот танхимд 14:00 цагт эхэллээ.

Ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Жаргалсайхан

Ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Д.Санжаа, гишүүн Т.Ганчимэг

Ээлжит хурлын тооллогын комиссын даргаар З.Төрболд, гишүүд Т.Ганчимэг, Б.Гэрэлт-Од нар байлцав.

Тооллогын комиссын дарга З.Төрболд:

Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц болон хурлын хүчин төгөлдөрт тооцох тухай Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67, 69 дүгээр зүйл заалтуудыг үндэслэн тогтоох нь 1,353,666 хувьцаа эзэмшигч 14 хувьцаа эзэмшийг өөрийн биеэр 1,268,996 хувьцаа эзэмшдэг 55 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар оролцож нийт гаргасан энгийн хувьцааны 2,622,662 ширхэг буюу 50.38%-ийг эзэлж байгаа учраас Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

Тооллогын комиссын даргад талархлаа. Хурлын ирц хүрсэн тул Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх тухай
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удиридах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах тухай
3. Хувьцаа хуваах тухай

Ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Д.Санжаа:

Хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд

тайлагнаж дүгнэлт гарсан тайлангаа та бүхэндээ товч танилцуулъя. Та бүхэн дэлгэцрүү анхаарлаа хандуулна уу.

Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК-ийн санхүүгийн тайлан эцэслэгдэж аудитын шалгалтаар орсон. Энэ аудитын тайлангаар компанийн санхүүгийн үзүүлэлтүүд дээшилсэн. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг харьцуулан үзэхэд компанийн үндсэн хөрөнгө болон эргэлдсэн хувьцааны хөрөнгө оруулалт мөн хуримтлагдсан ашиг илт өсөж орж ирсэн байгаа. Энэ нь болохоор хувьцаат орон сууц хөтөлбөрийг Өргөө ногоон хөгжил ХХК-ийг тусгаарлаж үйл ажиллагаагаа явуулж байгаатай холбоотой гэж үзэж байна. Дансны авлага цэвэршүүлсэн дүнгээр 2020 онд 3,5 тэрбум, 2021 1,4 тэрбум, 2022 онд 1,4 тэрбум, 2023 онд барилгын компаниуд болон бусад компаниудтай хийсэн гэрээнүүд цуцлагдах нь цуцлагдаж авах ёстой дүнгүүд нь 2,7 тэрбум болж өссөн байдлаар гарч ирсэн. Урьдчилж төлсөн зардал болон байранд төлсөн төлбөр нийтдээ 5,5 тэрбум, үндсэн хөрөнгө бол

/2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг товч танилцуулав./

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

Гүйцэтгэх удирдлагадаа баярлалаа. 2023 оны санхүүгийн тайлангаас харахад авлага гаргаж ирж байгаа сайн гүйцэтгэх удирдлагын баг хамт олон сайн ажилласан байна. Хувьцаа эзэмшигчдийн хувьд энэ нь муу үзүүлэлт гэж харж байна.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

Хувьцаа эзэмшигч та бүхэнд асуух асуулт байхгүй бол Тогтоол №01 тайлангийн дүгнэлтийг батлах уу?

Гишүүд:

Батлъя гэв.

Хоёрдугаар асуудал: Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удиридах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах тухай

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

2023 онд ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ын 2024 оны 2-р сарын 18- ний өдрийн 1 тоот тогтоолийг зөвшөөрсүгэй, 2024 онд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлж, ашигтай ажиллах ногдол ашиг хувиарлах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай гэсэн тогтоолын төсөл байна. Заа энэ

Гишүүд:

Байхгүй гэв.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

№02 тогтоолыг батлах уу?

Гишүүд:

Батлъя гэв.

Гуравдугаар асуудал: Хувьцаа хуваах тухай

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 51, 62 дугаар зүйл, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт гаргсан 5,205,600 ширхэг энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэг бүр нь 1 мөнгөний нэрлэсэн үнэтэй нийт 520,560,000 ширхэг хувьцаа болгосугай.
2. Хувьцаа хуваахтай холбогдуулан компанийн дүрэм дэх нийт зарласан хувьцааг 100,520,560,000 ширхэг болгон нэмэгдүүлж, дүрмийн өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлсүгэй.
3. Хувьцаа хуваахтай холбогдуулан “Хувьцаа хуваах үйл ажиллагааг гүйцэтгэх журам”-ыг хавсралтаар, “Хувьцаа хуваах төсөл”-ийг__-р хавсралтаар баталсугай.
4. Энэхүү тогтоол гарч байгаатай холбогдуулан “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрмийн төслийг -р хавсралтаар өөрчлөн найруулахыг зөвшөөрсүгэй.
5. Санхүүгийн зохицуулах хорооноос Хувьцаа хуваах шийдвэрийн зөвшөөрөл гармагц Компанийн дүрмийн төслийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн газраар батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ж.Жаргалсайхан/-д даалгсагуй.
6. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ж.Жаргалсайхан/-д даалгсагуй гэсэн №03 дугаар тогтоолыг уншиж танилцуулав. Хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу?

Гишүүд:

Байхгүй гэв.

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

№03 тогтоолыг батлах уу?

Гишүүд:

Батлъя гэв.

Тооллогын комиссын дарга З.Төрболд:

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх тухай зөвшөөрсөн 2,622,662 буюу татгалзсан, түдгэлзсэн байхгүй 100 хувь
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удиридах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулах тухай зөвшөөрсөн 2,622,662 буюу татгалзсан, түдгэлзсэн байхгүй 100 хувь
3. Хувьцаа хуваах тухай зөвшөөрсөн 2,622,662 буюу татгалзсан, түдгэлзсэн байхгүй 100 хувь

Тооллогын комиссын дарга З.Төрболд

Хурлын дарга Ж.Жаргалсайхан:

Саналаа өгсөн хувьцаа эзэмшигчдээ баярлалаа. Эдгээр санал хураалтын дагуу тогтоолын төслөө танилцуулав.

Заа бүгдэд нь баярлалаа. Бүгд санал нэг байна гэж ойлголоо. Бүгд тогтоол дээрээ гарын үсгээ зураад хурлаа өндөрлөө.

ТУЗ-ийн дарга хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлэн хурлыг хаав. Хурал 17:50 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Б.Гэрэлт-Од

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН